



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/21

Шивээговь сум

О.Оюунбилэгт буцалтгүй тусламж
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2 дугаар багийн иргэн Осорын Оюунбилэг нь эрүүл мэндийн шалтгааны улмаас төлбөртэй эмчилгээ удаа дараа хийгдсэн тухай хувийн өргөдлийг ирүүлсэн тул 300000 /гурван зуун мянга/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжаар олгох 300000 /гурван зуун мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс тооцож олгохыг нягтлан бодогч /Б.Түвшинжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох материалыг бүрдүүлж хавсаргахыг Нийгмийн бодлогын мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Сувд-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ламням* П.ГАНЧИМЭГ

